



## УРЬДЧИЛСАН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

2016 оны 02 дугаар сарын 26-ны өдөр

Монголбанк нь эрх бүхий этгээдийг Ховд аймаг дахь Монголбанкны салбарын барилгын зураг төслийг боловсруулах урьдчилсан сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна. Урьдчилсан сонгон шалгаруулалтад оролцохыг сонирхсон эрх бүхий этгээд нь дараах материалыг бүрдүүлж, 2016 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 10.00 цагаас өмнө ирүүлнэ үү.

-компанийн танилцуулга, албан бичиг;

-хуулийн этгээдийн гэрчилгээ болон холбогдох тусгай зөвшөөрлийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

-сүүлийн 2 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

-үндсэн ажилтнуудын боловсролын болон ажлын туршлагын талаарх мэдээлэл;

-сүүлийн 3 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалт /зургийн хамт/, захиалагчтай холбоо барих хаяг.

Урьдчилсан сонгон шалгаруулалтад оролцох компани нь дээр дурдсан материалыг бүрэн бүрдүүлж, битүүмжилж ирүүлэх шаардлагатай. Тэнцсэн компанитай холбоо барих тул холбогдох утасны дугаараа компанийн танилцуулга, албан бичигт тодорхой тусгана уу.

Материал хүлээж авах хаяг:

Монголбанк, Бага тойруу-3, 15160, Улаанбаатар хот,  
Монголбанкны “А” байрны 1 дүгээр давхар 2 тоот өрөө.

Утас: 310633, Факс: 311471

ооо